

ДУНДГОВЬ АЙМАГТ 2022 ОНД ХЭРЭГЖИЖ БУЙ  
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД  
ХИЙСЭН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН

2023 оны 01 дүгээр сарын 20

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО**

Монгол Улсын Хууль, УИХ, УИХ-ын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаврыг хэрэгжүүлэхээр хяналтад авсан шийдвэрийн заалтуудын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагуудыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, нийгэмд үзүүлж буй эерэг болон сөрөг нөлөөг тогтоох замаар цаашид хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд оршино.

**ХОЁР.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэхдээ тайлан мэдээлэл, түүнийг нотолж буй баримтад тулгуурлан хяналт-шинжилгээ үнэлгээг хийсэн бөгөөд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг орон нутагт чанартай, үр дүнтэй зохион байгуулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, түүний хэрэгжилт үр дүнгийн талаар аймгийн удирдлагуудыг болоод Засгийн газрын Хэрэг эрхлэх газрыг үнэн зөв мэдээллээр хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан **“БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ”**-д заасан үнэлгээ хийх аргачлалын дагуу гүйцэтгэлээ.

Аймгийн хэмжээнд хэрэгжиж байгаа Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жагсаалтыг гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэн үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, үр дүнд явцын хяналт шинжилгээг тусгай удирдамж гарган аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 24 газар, хэлтэс, агентлагт зохион байгуулан зөвлөн тусалж ажиллалаа.

Шинээр батлагдан гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг танилцах хуудсаар цохолт хийж, харьяа хэлтсүүд хяналтдаа авахаас гадна төрийн байгууллагын цахим системд бүх төрийн албан хаагчдад нээлттэйгээр байршуулж хяналтад авхуулж байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг тамгын газрын захиргааны зөвлөлийн хуралд танилцуулан удаашралтай хэрэгжиж буй тогтоол шийдвэрийг эрчимжүүлж ажиллахыг хурлын тэмдэглэлээр үүрэг болгох ажил хэвшил болоод байна.


## ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Дундговь аймагт 2022 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан /[unelgee.gov.mn](http://unelgee.gov.mn)/-д байршуулсан **40** шийдвэр: МУ-ын хууль- 68, УИХ-ын тогтоол -2, УИХ-ын байнгын хорооны тогтоол- 2, Ерөнхийлөгчийн зарлиг -14, ҮАБЗ-ийн зөвлөмж-8, Засгийн Газрын тогтоол-11, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл-12, ЗГ-ын албан даалгавар 3-ийн **120** заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээг хийлээ.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтийг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс авч нэгтгэн, ирүүлсэн тайланд Засгийн газрын 2020 оны 206-р тогтоолоор баталсан БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ-ын 6.3-д заасан үнэлгээ өгөх аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нийт 120 заалтын биелэлт 95.2 хувьтай байна. Хэрэгжилтийг үнэлгээний үе шат тус бүрээр нь авч үзвэл:

- Бүрэн хэрэгжсэн 100 заалт нь нийт заалтын 83.3 хувийг
- Хэрэгжих шатандаа байгаа 6 заалт нь 5 хувийг
- Хэрэгжилт хангалтгүй хэрэгжсэн 5 заалт нь 4.2 хувийг
- Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй болон аймагт хамааралгүй заалтууд 9 заалт 7.5 хувийг эзэлж байна.

Графикаар харуулбал:



Дундговь аймагт хэрэгжиж байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жагсаалт болон биелэлтийг Dundgovi.gov.mn сайт болон төрийн байгууллагын цахим программ болох egr.e-mongolia.mn программын файлын сан хэсэгт байршуулж, мөн мэдээллийн самбарт байршуулан мэдээллээр ханган ажиллаж байна. Мөн явцын хяналт шинжилгээгээр төрийн байгууллагуудыг мэдээллээр хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

### Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтын хэрэгжилтийн мэдээлэл

Агуулга	Бүгд	Үүнээс								
		МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	ЗГ-ын тогтоол	ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	ЗГ-ын албан даалгавар	
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	40	8	2	2	5	4	6	10	3	
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	120	68	2	2	14	8	11	12	3	
Үүнээс	Бүрэн хэрэгжсэн /100%/	100	59	2	2	13	7	10	5	2
	Хэрэгжих шатандаа 70%	6	1			1			3	1
	Хэрэгжилт хангалтгүй 30%	5	1				1		3	
	Хэрэгжээгүй 0%	-								
	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	9	7					1	1	
Хяналтнаас хасах санал	58	52	2		1		1	1	1	
<b>БИЕЛЭЛТИЙН ДҮН /Хувь/</b>	<b>95,2</b>	<b>98,3</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>97,8</b>	<b>91,2</b>	<b>100</b>	<b>72,7</b>	<b>90</b>	

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс харахад Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол, Засгийн газрын тогтоолын хэрэгжилтүүд 100 хувьтай буюу үр дүнтэй хэрэгжсэн байна. Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр өгсөн 12 заалтын дундаж 72,7 хувийн хэрэгжилттэй буюу хамгийн бага хувьтай байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 46 заалтын үр дүнг Засгийн газрын 374 дүгээр тогтоолын 9 дүгээр хавсралтын дагуу тусад нь тайлагнадаг тул хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дүнг тайлагнахаас гадна заалт бүрийг хяналтаас хасуулах саналаа давхар оруулсан.

**Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлснээр аймаг орон нутгийн хэмжээнд тодорхой үр дүн гарснаас дурдвал:**

**2019.01.01. ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ / 2017-12-07 / МУ-ЫН ХУУЛИЙН 55.3. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛЖ ХЭРЭГЖҮҮЛНЭ.ГЭСЭН ЗААЛТЫГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА.**

2021-2025 онд Дундговь аймгийн "Хүний нөөцийг хөгжүүлэх" дэд хөтөлбөрийг төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2 зорилтын хүрээнд боловсруулан аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулан ажиллаж байна. "Хүний нөөцийг хөгжүүлэх" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт 96 хувьтай байна.





ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭД, ИРГЭНИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨВИЙН БАРИЛГА АШИГЛАЛТАД ОРЛОО



АЙМГИЙН АХМАДУУД ӨРГӨӨТЭЙ БОЛЛОО



# НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ / 2021-12-17 / МУ-ЫН ХУУЛЬ ОРОН НУТАГТ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖИЖ БАЙНА

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт хангах үүднээс төрийн байгууллагуудын ил олд байдлыг хангах 46 шалгуур үзүүлэлтийн дагуу аймгийн сайт /dundgovi.gov.mn/-ын цэсийг үүсгэн шалгуур үзүүлэлтийн дагуу холбогдох мэдээллүүдийг байршуулан тогтмол шинэчилж байна. Мөн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлагууд болон сумдын Засаг даргын Тамгын газрын мэдээллийг 46 шалгуур үзүүлэлтийн дагуу цэс үүсгэн мэдээллийг ил тод байршуулж үр дүнг ажил дүгнэх үзүүлэлтэд оруулан тооцож байна.

Танилцуулга ЗАСАГ ДАРГА ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР ЭРХ ЗҮЙН АКТ МЭДЭЭ ИЛ ТОД БАЙДАЛ ТАСЭВЛӨЛ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД СУМД EN

ДУНДГОВЬ ХӨГЖИНӨ ХҮНИЙ ХӨГЖИЛ ДЭМЖИХ Н

- Үйл ажиллагааны ил тод байдал
- Хүний нөөц
- Бодлого, шийдвэр
- Өргөдөл, гомдол, санал хүсэлт
- Тендерийн урилга
- Төсөв санхүү
- Авлигатай тэмцэх үйл ажиллагаа
- Статистикийн өврийн дэвтэр
- Аймгаас дэвшүүлсэн зорилт
- Үйлчилгээ авахад шаардлагатай бичиг баримтын жагсаалт
- Нээлттэй хэлэлцүүлэг
- Шинэ санал санаачилга
- Төрийн бус байгууллагын мэдээлэл
- Тусгай зөвшөөрөл
- Төсөл хөтөлбөр
- Тайлан, зөвлөмж, дүгнэлт
- Утасны жагсаалт

ЦӨӨН ҮГЭЭР ▶ СУМЫН ХӨГЖИЛ ТӨРИЙН АЛБАНЫ ЕРӨНХИЙ ШАЛГА

ХУДАЛДАА, ҮЙЛЦЭЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

ҮЙЛЧИЛГЭЭ

ТАВИЛГА, МОД МОДОН БҮТЭЭГДЭХҮҮН

ОЁДОЛ, СУЛЖМЭЛ ЭДЛЭЛ, ЭСГИЙ БҮТЭЭГДЭХҮҮН

БЭЛЭГ ДУРСГАЛ, ГОЁЛ ЧИМЭГЛЭЛ

дундговь аймаг төрийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудас

Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал

№	Үзүүлэлт	Төлжж авах хэлбэр
1	Ажлын байрны сүл орон тооны талаар мэдээлэл	далгэрэнгүй
2	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам	далгэрэнгүй
3	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм	далгэрэнгүй
4	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг өмнө үзэх журам	далгэрэнгүй
5	Хүний нөөцийн зардалын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ	далгэрэнгүй
6	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам	далгэрэнгүй

АДААЦАГ

- Танилцуулга
- Байгууллагууд
  - ИТХурал
  - ЗДТГазар
  - Сургууль
  - Цэцэрлэг
  - Зоюу мөндрийн төв
  - Сийлэйн төв
- Мэдрэ мэдээлэл
- Ил тод байдал
  - Хүний нөөц
  - Төсөв санхүү
  - Үйл ажиллагаа
  - Төрийн үйлчилгээ
  - Бусад

Байгаль орчин, аялал жуулчлалын газар Дундговь аймаг

NO TO CORRUPTION

ХҮНИЙ НӨӨЦ ТӨСӨВ, САНХҮҮ ҮЙЛ АЖИЛЛАГАА АЖЛЫН ТАЙЛАН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Олон улсын авлигын эсрэг өдөр

АВЛИГЫН ЭСРЭГ ОЛОН УЛСЫН ӨДӨР 12 САРЫН 09 (АВЛИГА ӨГӨНГҮЙ) БАС АВАХТИЙН

МАЛ, АМЬТНЫ ГЭДЭГ КВАРАНТАЙН ШУЛГИЙ ӨРӨНЧИЙ ҮЕД МЭРГЭЛЭГ БОЛТОН АЖИЛЛАХ ЗӨВӨӨМЖ

Сумын Байгаль орчны амьтлын үрчин байцаагч, байгаль хангаалагч нарт олгуулыг зөвлөж: 1. Байгаль орчны амьтлын үрчин байцаагч, байгаль хангаалагч нар урса 24 цагийн турш нээлттэй байгаа. 2. Голынтын бүсэд амьтлах байгаа БОХМБайцагч, Байгаль хангаалагчид цагийн байдлын мэдээллийг нэрв бүр Байгаль орчин, аялал жуулчлалын газрын шуурхай мессежийн 70533980 дугаарт шуудан. 3. Өвчний шинж тэмдэг илэрсэн, усан амьтдын талаар мэдээллийг цаг алдалгүй холбогдох газарт мэдээлэх. БОААГ-ын 70533980, ОХ-ын ирдэглэсэн байрны 70532295/

ЗАСГИЙН ГАЗАРТ ЧИГЛЭЛ ӨГӨХ ТУХАЙ /ТЭРБУМ МОД/ / 2021-10-04 /  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ ДУНДГОВЬ АЙМАГТ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖИЖ БАЙНА.

"Тэрбум" мод үндэсний хөдөлгөөнийг орон нутагт хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Дундговьно ногооруулъя" дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд аймгийн ИТ Хурлын тогтоолоор 2022 онд 240.0 сая төгрөг батлуулсан.

Үүний үр дүнд аймгийн хэмжээнд 122884 мод сөөг тарьж ногоон байгууламжийн хэмжээ өмнөх оноос 51 хувиар нэмэгдсэн.



2022\_159. ЭЗЭН БОГД ЧИНГИС ХААНЫ ЭШ ХӨРГИЙГ ХҮНДЭТГЭН ЗАЛАХ ТУХАЙ / 2022-07-11 / ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД АНХААРЧ АЖИЛЛАЖ БАЙНА.

"Монгол бахархлын өдөр"-ийг тохиолдуулан аймгийн ИТХ-аас санаачлан 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр "Монгол бахархал" арга хэмжээг зохион байгуулж,

Чингис хааны мэндэлсний 860 жилийн ой тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эзэн богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах зарлиг гарсан тухай танилцуулан, төрийн байгууллага, Монгол хүн, айл өрх бүр Чингис хааны эш хөргийг залахыг уриалан 15 сумын удирдлагуудад Чингис хааны эш хөргийг гардуулан өглөө. Боловсролын 19 сургууль, 22 цэцэрлэг Чингис хааны эш хөргийг 2022 оны 09 сарын 01-ний өдөр хүндэтгэлтэйгээр залсан.

"Монгол үндэстний үнэт зүйл" бахархлыг алдаршуулах хүрээнд "Чингисийн эш хөрөг" залах, сургаалыг дээдлэх талаар төрийн байгууллага, бүх шатны сургалтын байгууллагууд, айл өрх бүрийг уриалсан цахим сурталчилгааг хийлээ.





## МОНГОЛ БИЧГИЙН ХЭРЭГЛЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТУХАЙ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ ОРОН НУТАГТ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖИЖ БАЙНА.

107 төрийн байгууллага гадна хаягаа болон өрөөний хаягийг, 236 албан хаагч нэрийн хуудас, 12 байгууллага мэдээллийн самбараа монгол бичгээр үйлдээд байна. Энэ нь нийт төрийн байгууллагын 63.1 хувь, сумдын 93,3 хувь нь монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.



## ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ / 2010-03-18 / ҮАБЗ-ИЙН ЗӨВЛӨМЖ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖИЖ БАЙНА

2022 онд Сайнцагаан сумын Хүмүүнлэг 3 дугаар сургууль, 2 дугаар цэцэрлэгийн барилгын буулгалтын ажлыг хийсэн. Мөн 1 үйлчилгээний барилгыг буулган 24 орон сууц төлөвлөн барилгын явц 95 хувьтай байна.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу орон нутгийн хүн амд гамшгаас хамгаалах тухай мэдлэг олгох, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх зорилгоор Гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг нийт 308 удаа, 484 цагийн сургалтыг зохион байгуулж 10685 иргэнийг хамруулсан нь орон нутгийн нийт хүн амын 22,7 хувийг эзэлж байна.

СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, АРГА ХЭМЖЭЭГ БАТЛАХ  
ТУХАЙ ЗГ-ЫН 314 ДҮГЭЭР ТОГТООЛЫГ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА.

"Гар урлалын бүтээл-2022" үзэсгэлэнг "Дундговьд үйлдвэрлэв" төвд зохион байгуулж, тус үзэсгэлэнд 4 сумын 20 гаруй урчуудын 190 гаруй бүтээлийг дэлгэн үзүүлээ.

Мөн "Нүүдэлчин Монгол-2022" наадмаар 19 гар урчуудын 7 ай савын төрлийн бүтээлийн үзэсгэлэн, "Адууны өв соёлтой холбогдолтой эд хэрэглэл", "Гар урлалын бүтээл-2022" үзэсгэлэн, худалдаа 7 сумын 33 гар урчуудын 228 бүтээлээр тус тус зохион байгуулагдлаа.



2022 ОНЫ 8 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР 42 ДУГААР ТЭМДЭГЛЭЛ / 2022-08-24 / ЗГ-ЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭР ӨГСӨН ҮҮРЭГ АЙМАГТ АМЖИЛТТЭЙ ХЭРЭГЖИЖ БАЙНА.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 139 дүгээр тушаалаар батлагдсан “Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо ”-ны журмыг хэрэгжүүлэх хүрээнд 5 удаагийн цахим хурлаар, 8 удаа албан бичгээр зөвлөмж, заавар, ажлын чиглэлийг өглөө.

Мөн 1,5 тэрбум төгрөгөөр Эрүүл мэндийг дэмжих төвийг ашиглалтад оруулан эрт илрүүлэлтийн үзлэг шинжилгээ, оношилгоог хийж байна. Зорилтот насны иргэдийг хамруулах үйл ажиллагааг 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлүүлж 6 бүлэг насны багцын үзлэгт 25300 хүн хамрагдахаас насанд хүрэгчдийн 4 багц үзлэгт 3943, 0-18 насны 2 багц үзлэгт 8327 хүүхэд тус тус хамруулж хамрагдалтын хувь 48,5 байна.



**Хэрэгжилт хангалтгүй байгаа болон хугацаа болоогүй заалтуудын шалтгаан**

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн **хэрэгжилт хангалтгүй 5** заалт байна.

Үүнд:

Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Шалтгаан
2019_60/40. Усны нөөцийг хамгаалах, хомсдолоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай / 2019-12-31 / ҮАБЗ-ийн зөвлөмж	2.11. Хот, суурин газрын үерийн хамгаалалтын далан, ус зайлуулах системийн найдвартай ажиллагааг хангах	Үерийн хамгаалалтын далан сувгийг бүрэн дуусгахад 5,1 тэрбум төгрөг нэмж шаардагдаж байгаа талаар 2022 оны улсын төсвийн программд шивэн Барилга, хот байгуулалтын яам руу хөрөнгийн асуудлыг шийдвэрлэхээр хүсэлт хүргүүлсэн боловч шийдвэрлээгүй ба 2023 оны улсын төсвийн төсөлд хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр саналаа хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй.	Хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй
2017.02.01. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/	18.1.3.Хүн амын тоо, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг харгалзан орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах;	Аймгийн хэмжээнд 2022 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 23 бүртгэгдсэнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 43.7 хувь, энэ төрлийн зөрчил 60 бүртгэгдсэнийг өмнөх он мөн үетэй харьцуулахад 30.4 хувиар тус тус өссөн байна. Орон нутгийн хөгжлийн сангаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд 250,000,000 төгрөгийн төсөвт өртөх бүхий “Түр хамгаалах байр бий болгох” саналыг шийдвэрлүүлсэн.	Хөрөнгийн асуудлаас болоод 2022 онд түр хамгаалах байргүй байсан
2021_19. 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр 19 дүгээр тэмдэглэл	II.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй дуусаагүй, олон жил үргэлжилж, хэрэгжилт нь удааширч байгаа төсөл, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг мэргэжлийн байгууллагатай хамтран нягтлан тогтоож, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж Засгийн газрын	Аймгийн удирдлагууд болон албаны холбогдох хүмүүс 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдөр Соёлын яамнаас томилогдсон ажлын хэсэгтэй Дундговь аймгийн Сайнцагаан суманд баригдаж буй Төв халхын дуулалт жүжгийн театрын барилга, Цагаандэлгэр суманд баригдаж буй Соёлын төвийн барилгын ажлын явц цаашид хэрхэн шийдвэрлэх талаар уулзалт хийсэн боловч тодорхой үр дүнд хүрч шийдэл гараагүй.	Суурь компани нь туслан гүйцэтгэгч компанитайгаа шүүхийн шатанд байгаа

	хуралдаанд танилцуулахыг холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав.		
2022_28. 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл	тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.	Тоон гарын үсгийг бүртгэлийн 16 нэгжээр дамжуулан олгож байгаа бөгөөд 16-аас дээш насны 32044 иргэнд тоон гарын үсэг олгохоос өнөөдрийн байдлаар 10982 иргэн буюу 34,0 хувьд олгоод байна. Тоон гарын үсгийг 9753 иргэнд иргэний үнэмлэхийн чипэнд, 1129 иргэнд гар утасны gsign app-аар дамжуулан олголоо.	Урт хугацааны туршид хэрэгжинэ.
2022_42. 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл	төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ чиглэлд салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	Зорилтот насны иргэдийг хамруулах үйл ажиллагааг 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлүүлж 6 бүлэг насны багцын үзлэгт 25300 хүн хамрагдахаас насанд хүрэгчдийн 4 багц үзлэгт 3943, 0-18 насны 2 багц үзлэгт 8327 хүүхэд тус тус хамруулж хамрагдалтын хувь 48,5 байна.	Урт хугацааны туршид хэрэгжинэ.

### Хугацаа болоогүй 9 заалтыг жагсаавал:

Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Шалтгаан
2022.06.03. Ойн тухай /Шинэчилсэн найруулга/	39.7. Ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний зардлыг аймаг, сум, нийслэл, дүүрэг жил бүрийн төсөвтөө тусгана.	Орон нутгийн онцлогоос хамааран өвс ургамал тачир, намхан ой хээрийн түймэр гарсан тохиолдол байгаагүй тул жил бүр ой хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний зардал төсөвт тусгагддаггүй. /
2022.05.01. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай	8.2.4. хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан гэж орон нутгаас гарах боломжгүй
	8.4.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;	2022 оны байдлаар аймагт ийм шийдвэр гараагүй байна.

	8.6.2. эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;	орон нутагт эзэмшиж байгаа оюуны өмч байхгүй
	8.6.10. мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;	Төрийн болон төрийн өмчийн байгууллагуудад хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд нөлөө үзүүлж буй нөлөөллийн талаарх мэдээлэл байхгүй.
	8.6.20. нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл;	Нээлттэй өгөгдөл байхгүй
2021-12-24. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль	11.3. Улсын Их Хурлаас энэ хуулийн 11.2-т заасны дагуу Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд Улсын Их Хуралд ирүүлэх ба түүнд Тамгын газар дүн шинжилгээ хийж, танилцуулгыг холбогдох Байнгын хороодод хүргүүлнэ.	Аймагт хамааралгүй заалт
2022_402. Орон сууцны хороолол, цогцолбор барилгад хүүхдийн цэцэрлэг байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай	4. Цэцэрлэгийн зориулалтаар баригдсан барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгөөр түрээслэх, худалдан авах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх, шаардагдах зардлыг жил бүрийн улс, нийслэл, орон нутгийн төсвийн төсөлд тусгахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Орон нутагт хувийн өмчийн түрээслэх, худалдах цэцэрлэгийн зориулалтаар баригдсан барилга байхгүй учраас шийдвэр гараагүй
2022_49. 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 49 дүгээр тэмдэглэл	XII.5.2. Байгууллагын мэдээллийн системийг “Үндэсний дата төв” УТҮГ-ын үүлэн системд байршуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын удирдлагад даалгав.	“Үндэсний дата төв”-д УТҮГ-ын үүлэн системд байршуулах хүсэлтийг хүргүүлсэн. Үндэсний дата төв”-ийн үүлэн серверийн үйлчилгээ түр хойшлогдсон.

## 2021 ОНЫ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД

Засгийн газрын хэрэг эрхлэх газраас аймгийн Засаг даргын тамгын газрын 2021 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмжийг ирүүлсэн. Зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган тамгын газрын даргаар батлуулан холбогдох хэлтэс агентлагуудад хүргүүлэн үр дүнг жилийн эцсийн ажлын үр дүнг үнэлэх үзүүлэлтэд оруулж ажиллав.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хүрээнд ирсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх тусгай төлөвлөгөө гарган эзэнжүүлж үр дүнг тооцож ажилласан.

Аймагт хэрэгжиж буй хууль, тогтоомж тогтоол шийдвэрийг бүрэн хяналтад авхуулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор явцын хяналт шинжилгээний удирдамж гарган 15 хэлтэс, агентлагт хуваарийн дагуу ажиллаж арга зүйгээр хангасан.

БАТЛАВ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ХҮНИЙН ГҮЙЦЭТГЭГЧ  
2022 оны 8 дугаар сарын 17

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРААС  
ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

2022 оны 8 дугаар сарын 17 ны өдөр

№	ЭХЭГ-ээс өгсөн зөвлөмж	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хураан туусдын	Хугацаа	Хариуцах
<b>Нэг: Бодлогын баримт бичгийг хэрэгжилтийн үнэлгээ</b>						
<b>Хууль тогтоомж, тогтоол шийдвэр</b>						
1	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгж сүм өөрийн харьяа байгууллага, газар, хэлтэстэй дүнгийн зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулах түүний мөрөөр өвч хэрэгжүүлэх өвчлөгч үндэстэй холбоотой зохион байгуулж ажиллах байсан үр дүнг бүрэлдсэн байна.	Явцын хяналт шинжилгээний удирдамж гарган холбогдох хэлтэс, агентлагуудад авах	Хяналт-шинжилгээний үнэлгээ	15	III Ууларсан	Д.Дарийн Б.Пэрэнцэг
2	Тодорхой шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй заалтуудын шалтгааныг тодорхойлж цаашид авах арга хэмжээний талаарх саналыг хэлэлцэж шийдвэрлэж байх асуудалд илүү анхи, гаргах.	Удаашралтай хэрэгжих байгаа болон тасарч болзошгүй, хэрэгжих боломжгүй заалтуудын жагсаалтыг гаргах.	Хяналт-шинжилгээний үнэлгээ	1	III Ууларсан	Д.Дарийн
3	Тодорхой шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй заалтуудын шалтгааныг тодорхойлж цаашид авах арга хэмжээний талаарх саналыг хэлэлцэж шийдвэрлэж байх асуудалд илүү анхи, гаргах.	Тодорхой шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй заалтуудын шалтгааныг тодорхойлж цаашид хэрэгжүүлэх талаар зөвлөмж өгч ажиллах.	Хяналт-шинжилгээний үнэлгээ	5	III Ууларсан	Д.Дарийн Б.Пэрэнцэг
4	Удаашралтай, тасарсан заалтуудын тоо өмнөх ондтой харьцуулахад бурсан ч хэрэгжилтийн явцыг бүс үр дүнг чухалчилж тайлалнах байдалд илүү анхи гаргах шийдвэрлэж байгаа нь хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн	Удаашралтай болон тасарч болзошгүй байгаа заалтуудын хяналтад авч холбогдох хэлтэс, агентлагуудад зөвлөмж өгч ажиллах.	Хяналт-шинжилгээний үнэлгээ	15	III Ууларсан	Д.Дарийн Б.Пэрэнцэг



БАТЛАВ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ХҮНИЙН ГҮЙЦЭТГЭГЧ  
2022 оны 8 дугаар сарын 17

УДИРДАМЖ

Мандаловь хот

Явцын хяналт шинжилгээ хийж, арга зүйгээр ханган, зөвлөмж туслах тухай

Зорилго: Мандал улаан Засгийн газар болон аймгийн Засаг даргын Тамгын газраас боловсруулж баталсан журмыг, Бодлогын зорилтын хэрэгжилтийг эрчимжүүлэх байгууллага үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх ниглэлээр төрийн албан хаагчид арга зүйг сургалт хийж, эзэн туслалтад оролцох.

Хугацаа: 2022 оны 04 дугаар сарын 27—ны өдрөөс 05 дугаар сарын 18—ны өдрийн дундтай.

Ажлын хэргийн бүрэлдэхүүн: Хяналт- шинжилгээ, үнэлгээний хэлтэс, холбогдох хэлтэсийн бодлого хариуцаж ажиллах.

Нэг: Хийж гүйцэтгэх ажлын ниглэл

АРГА ЗҮЙН СУРГАЛТ

- Бодлогын баримт бичиг болон захирагчийн бодлуулганы үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтэл журмын өөрчлөлт
- Төлөвлөлт ба хяналт шинжилгээ, үнэлгээний үүлдэр холбоо тайлан шалтгад ачаарах асуудал


ЯВЦЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ БОДЛОГИН БАРИМТ БИЧИГ

- Дундговь аймаг хэрэгжиж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авах, эрчимжилтийг эрчимжүүлэх
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан тухайн байгууллага хамрагдсан төрийн албан хаагчид үйл ажиллагаа хэрэгжүүлэх зорилтын хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөсөн байдал
- Засгийн газрын зарим чиг үүргийн зарим нэгдэл төлөвлөх хэрэгжүүлэх зорилтын хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөсөн байдал
- Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлт ба өмнөх онд суулан бодлогын хэрэгжилт
- Төрийн албан хаагчийн сургалт нийгмийн баталгааг хангах тухайн жилийн төлөвлөгөөний төлөвлөгөөний байдал
- Зөвлөмж, зөвлөмжийн хэрэгжилт үнэлгээний үнэлгээний шинэчлэх тухай
- Хяналт шинжилгээ, үнэлгээний багас өгсөн зөвлөмжийн хэрэгжилт
- Нэрвүүлсэн ил тоо байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтийн өөрчлөлтийн тухай

15 агентлагт хамааралтай 18 шийдвэрийн 31 заалт удаашралтай хэрэгжиж байгаа болон тасарч болзошгүй, хэрэгжих боломжгүй байгааг хяналтад аван жагсаалтаар холбогдох хэлтэс, агентлагууд руу хүргүүлэн үр дүнг жилийн эцсийн ажил дүгнэх үзүүлэлтэд оруулан тооцон ажилласан.

Хөрөнгийн асуудал нь шийдвэрлэгдэхгүй байгаа болон цаг хугацаанаас шалтгаалан хэрэгжих боломжгүй 14 заалтыг эрчимжүүлэх чиглэлээр холбогдох 5 агентлагт зөвлөмжийг өгч ажилласан.

Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд сар бүр хяналт шинжилгээ, үнэлгээг хийж тайланг удирдлагын зөвлөлийн хурлаар оруулан ЗГХЭГ-ын [unelgee.gov.mn](http://unelgee.gov.mn) цахим санд байршуулан баталгаажуулж хэвшээд байна.



2022 оны 8 сард өмнө нь гарсан шийдвэр, заалтыг нэг бүрчлэн шүүн үзэж хэрэгжиж дууссан, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон заалтууд болон хэрэгжилт тогтмолжсон норматив шинжтэй шийдвэрийн заалтууд болон Засгийн газрын тогтоолоор батлагдсан хөтөлбөр, журмуудыг дотоод хяналтдаа авахаас гадна 19 шийдвэрийн 23 заалтыг Засгийн газрын хяналт- шинжилгээ, үнэлгээний мэдээллийн сангаас тэмдэглэл хийн хасуулсан.

2022 оны эхний хагас жилийн тайлангаас хэрэгжилт хангалтгүй байгаа шийдвэр, заалтын мэдээллийг хэлэлцэхээр аймгийн удирдлагууд бодлогын 3 хэлтсийн мэргэжилтний хамт холбогдох 15 агентлагийн удирдлагуудыг дуудан удаашралтай хэрэгжүүлж буй тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг сонсон ажил эрчимжүүлэх чиглэлээр үүрэг чиглэл өгч ажилласан.





## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дундаж дүн 95.2 хувьтай байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч, хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих, хэрэгжилтийг цаг хугацаанд нь чанартай тайлагнахад ахиц дэвшил гарч байгаа нь хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр шат шатандаа төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулж, тайлан мэдээллийг аймгийн удирдлагуудад танилцуулан үүрэг чиглэл өгөх ажил хэвшил болсонтой холбоотой гэж үзэж байна.

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг тусгай удирдамж, шалгуур үзүүлэлтийг урьдчилан гаргаж холбогдох газруудад хүргүүлэн, хяналт-шинжилгээний явцад болон дууссаны дараа ажил сайжруулах чиглэлээр тайлан, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох газруудад хүргүүлж хэрэгжилтийн явцад хяналт тавьж заавар, зөвлөмж нэгдсэн удирдлагаар хангаж ажилласны үр дүнд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт сайжирч байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сар бүр авч байгаа нь жилийн эцсээр хэрэгжилтийн хувь нэмэгдэхэд эерэг нөлөө үзүүлж байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс харахад Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол, Засгийн газрын тогтоолын хэрэгжилтүүд 100 хувьтай буюу үр дүнтэй хэрэгжсэн байна. Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр өгсөн 12 заалтын дундаж 72,7 хувийн хэрэгжилттэй буюу хамгийн бага хувьтай байгаад анхаарах шаардлагатай байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хүрээнд шинээр гарсан шийдвэрийг цаг алдалгүй судлах ажлыг шат шатандаа хийх, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг байгууллагын болон хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах, аймгийн удирдлагуудыг судалгааны үр дүнд суурилсан мэдээллээр хангах нь зүйтэй гэж үзэж байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 46 заалтын үр дүнг Засгийн газрын 374 дүгээр тогтоолын 9 дүгээр хавсралтын дагуу туст нь тайлагнадаг тул хууль тогтоомж, тогтоолын шийдвэрийн хэрэгжилтэд оруулан тайлагнах нь тайлагналтын хувьд давхцал үүсэж албан хаагчдад ачаалал нэмэгдэж байгаа тул хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтээс хасах нь зүйтэй гэж бодож байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үр дүнг [unelgee.gov.mn](http://unelgee.gov.mn) цахим программд байршуулахдаа шийдвэрийн заалт бүрийн ард холбогдолтой нотлох баримтыг хавсаргасан болно.

## **ТАВ. ЗӨВЛӨМЖ**

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг гаргахдаа үйл явцыг бус үр дүн, үр нөлөөг тодруулан бичиж нотлох баримтыг хавсаргаж хэвших
2. Хэрэгжилт нь тогтмолжсон болон тусгайлан он зааж хугацаандаа бүрэн хэрэгжээд дууссан, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан саналуудыг хяналтаас хасуулах саналаа ирүүлж хэвших
3. Бодлогын хэлтсүүд хэрэгжилт хангалтгүй, хугацаа болоогүй заалтуудыг холбогдох агентлагуудад хүргүүлэн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулан хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах
4. Шинээр гарч буй Хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийг хяналтад авч хэрэгжүүлэхэд санал санаачилга гарган ажиллах
5. Шинээр гарч буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийг сурталчлах, иргэдэд мэдээлэх ажлыг эрчимжүүлэх

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**